



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ХОА-2025/016/НА-СТА-ТТЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Д.Нямгарав Утас: 99478813 Цахим хаяг: nyamgaravd@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**БУЛГАН СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.ГАНТУЛГА ТАНАА**

2025.03.25 № 2/120.  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### **Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ховд аймгийн Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.3, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, сангийн үйл ажиллагааны журмын 3.2.2, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 2.8 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ОНХС-аас 58,979.6 мянган төгрөгийн он дамжсан төслийн урьдчилсан санхүүжилт олгоод авлагаар бүртгээгүй,
- ОНХСан болон Хоршоо хөгжүүлэх сангаас санхүүгийн анхан шатны баримт бүрдэлт дутуу байхад ажил гүйлгээ хийсэн, бүртгэлээр тавих хяналт сул байгаатай холбоотой 86,832.8 мянган төгрөг,
- Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 1,650.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан,
- Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтүүд хуваарийн дагуу хийгдээгүй 35,083.5 мянган төгрөг,
- "Минжит булганы буян" ОНӨААТҮГ нь Бизнес инкубаторын төвийн 2024 оны 09 сараас хойшхи түрээсийн орлого 12,870.0 мянган төгрөгийг хувийн харилцах дансанд төвлөрүүлсэн,

- “Минжит булганы буян” ОНӨААТҮГ-аас гэрэлтүүлгийн засварт 6,500.0 мянган төгрөгийг хувийн харилцах дансанд шилжүүлсэн, хийсэн ажил, бүрдүүлсэн баримт бичгүүд нь зөрүүтэй, ажлын тайлангүй, санхүүгийн анхан шатны бүртгэлээр тавих хяналтгүй
- Сумын санхүүгийн алба, төрийн сангаас хэрэгжүүлсэн дотоод хяналт сул зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Булган сум нь 2024 оны татварын болон татварын бус орлого өмнөх оноос 215.8 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт 457.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь 16.2 сая төгрөг буюу 3.7 хувиар төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны малын тоо толгойн албан татвар, газрын төлбөр, хүү торгуулийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,087,946.8</b>	<b>1,690,699.8</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>473,910.5</b>	<b>1,138,364.4</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>576,239.2</b>	<b>505,804.2</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>27,797.1</b>	<b>46,531.2</b>
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	10,000.0	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,427,233.4</b>	<b>11,191,337.2</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,427,233.4	<b>11,191,337.2</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	6,185,460.8	10,949,616.6
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	241,772.7	241,720.6
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,515,180.2</b>	<b>12,882,037.1</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	3,363.4	4,549.3
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,363.4	4,549.3
<b>41300</b>	<b>Өглөг</b>	3,363.4	4,549.3
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,511,816.9</b>	<b>12,877,487.8</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,511,816.9</b>	<b>12,877,487.8</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,313,277.7	1,313,277.7
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>5,851,650.2</b>	<b>11,230,249.9</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	346,888.9	333,960.1
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,515,180.2</b>	<b>12,882,037.1</b>

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,876,314.1</b>	<b>10,942,277.9</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	1,267,085.9	2,454,558.6
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	1,101,392.5	2,311,360.1
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	1,167,964.1	2,401,835.2
<b>1101</b>	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>	(66,571.6)	(90,475.1)
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	60,483.5	73,164.0
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	105,209.80	70,034.5
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>969,485.80</b>	<b>5,615,426.9</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>969,485.80</b>	<b>5,615,426.9</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	2,639,742.40	2,872,292.3
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	4,166,674.40	5,569,968.9
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,166,674.40	5,569,968.9
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,144,852.10	5,512,184.6
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	636,796.90	977,702.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	79,479.20	119,120.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	120,307.50	1,718,187.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,082,186.30	1,846,588.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	7,629.00	2,498.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,118.70	14,482.3
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	14,385.10	17,975.3

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	405,686.90	90107.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	782,262.40	725,523.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,822.30	57,784.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	709,639.70	5,372,308.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	(6,638.0)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	709,639.70	5.365.670.9

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**(мянган төгрөгөөр)**

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,337,168.30	5,795,267.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,267,085.90	2,454,558.6
110	Орлогын албан татвар	1,101,392.60	2,311,360.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,167,964.10	2,401,835.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(66,571.60)	(90,475.1)
113	Хөрөнгийн албан татвар	60,483.60	73,164.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	105,209.80	70,034.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	33,469.70	29,728.4
1181	Газрын төлбөр	62,032.00	29,668.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	9,708.10	10,637.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	430,340.00	468,416.3
120	Нийтлэг татварын бус орлого	430,340.00	468,416.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,639,742.40	2,872,292.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,710,297.50	3,362,653.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,710,297.50	3,362,653.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,685,998.30	3,304,869.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	698,482.70	1,109,848.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,875.20	168,242.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,071.30	1,7125,128.2
2104	Хангамж, бараа материалын зардал	73,667.10	79,746.8
2105	Нормативт зардал	1,091.20	1,178.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,714.40	14,482.4
2107	Томилолт, зочны зардал	14,729.10	16,485.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	472,378.20	104,670.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	239,989.10	85,086.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,299.20	57,784.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,626,870.80	2,432,613.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,140,160.40	1,705,618.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,140,160.40	1,705,618.7
2200	Дотоод эх үүсвэрээр	2,140,160.40	1,705,618.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,140,160.40)	(1,705,618.7)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(114,594.40)	(62,541.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	257,100.00	62,541.0

**Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	372,115.9	664,453.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	101,794.5	473,910.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	473,910.5	1,138,364.4

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,313,277.6	346,888.9	5,142,010.5	6,802,177.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			12,928.7	12,928.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,313,277.6	346,888.9	5,142,010.5	6,802,177.1
4	Тайлант үеийн үр дүн	-	-	709,639.7	709,639.7
5	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,313,277.6	346,888.9	5,851,650.2	7,511,816.8
6	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,313,277.6	346,888.9	5,851,650.2	7,511,816.8
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,313,277.6	346,888.9	5,864,579.0	7,524,745.6
8	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		(12,928.7)		(12,928.7)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	5,365.6	5,365.6
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,313,277.6	333,960.1	11,230,249.9	12,877,487.8

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 245,007.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч баталгаажуулав.

Илэрсэн алдаа зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс “их” байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 245,007.7 мянган төгрөгийн 7 зөрчил<sup>1</sup> илэрснээс 121,441.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулан 123,566.3 мянган төгрөгийн 3 заалт бүхий зөвлөмж өгч ажиллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Булган сум ТТЗ	1	58.9			1	58.9	1	58.9				
	1	58.9			1	58.9	1	58.9				
	1	1.7	1	1.7			1	1.7				
	1	1.7			1	1.7	1	1.7				
Дүн	4	121.4	1	1.7	3	119.7	4	121.4				

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Булган сум	1	86.8					1	86.8				
ТТЗ	1	36.7					1	36.7				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>123.5</b>					<b>1</b>	<b>123.5</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
<b>Нийт дүн</b>										

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	3	1	2	0	1	0	0	0
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	2		2					
4	ТТЗ	1	1				1		
5	ОНӨААТҮГ	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>5</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>